

2018.06.13

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ..... дугаар сарын .....-ны өдөр

Улаанбаатар хот

БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

(шинэчилсэн найруулга)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь банк бус санхүүгийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, тогтвортой хөгжлийг хангах, зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэгч болон банк бус санхүүгийн дундын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, албадлагын арга хэмжээ авахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж

2.1.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль тогтоомж нь Иргэний хууль, Компанийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.

3.2. Засгийн газрын тусгай зориулалттай сан, төслийн нэгжээс олгох зээлийн үйл ажиллагаа, банк, даатгал, үнэт цаасны компани, хөрөнгө оруулалтын сан, тэтгэврийн сан, хадгаламж, зээлийн хоршоо, барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааг холбогдох бусад хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“банк бус санхүүгийн үйл ажиллагаа” гэж Хорооноос тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдийн эрхлэх энэ хуулийн 6.1, 6.2-д заасан үйл ажиллагаа, үйлчилгээг;

4.1.2.“банк бус санхүүгийн байгууллага” гэж хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдсэн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, хувьцаа эзэмшигч нь эзэмшиж байгаа хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээдэг, энэ хуулийн 6.1, 6.2- дэх хэсэгт заасан үйл ажиллагаа, үйлчилгээг Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлдэг, 6.4-т заасан ашгийн төлөө хуулийн этгээдийг;

4.1.3. “гадаад валютын арилжаа” гэж гадаад валютыг бэлэн болон бэлэн бус хэлбэрээр худалдах, худалдан авахыг;

4.1.4. “факторингийн үйлчилгээ” гэж үүрэг гүйцэтгүүлэгчээс мөнгөн төлбөрийн үүргийг шаардах эрхийг худалдан авах, гуравдагч этгээдэд худалдах, шилжүүлэх үйлчилгээг;

4.1.5. “төлбөрийн баталгаа, батлан даалт гаргах” гэж Иргэний хуулийн 457, 458 дугаар зүйлд заасныг;

4.1.6. “санхүүгийн хэрэгсэл гаргах, худалдах, худалдан авах” гэж Үнэт цаасны зохицуулалтын тухай хуулийн 4.1.6-д заасныг;

4.1.7. “цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ” гэж бусдын мөнгөн хөрөнгийг банкн дахь өөрийн харилцах дансаар дамжуулан интернет, автомат тоног төхөөрөмж, цахим төлбөр тооцооны хэрэгсэл ашиглаж, төлбөр тооцоог гүйцэтгэх ажиллагааг;

4.1.8. “итгэлцлийн үйлчилгээ” гэж итгэл хүлээлгэгчийн актив /мөнгө хөрөнгө, зээл, бусад актив/-ыг үнэгүйдлээс хамгаалж, ашиг олж өгөх зорилгоор тэдгээртэй харилцан тохиролцсон гэрээний үндсэн дээр итгэл хүлээгчээс нэр бүхий активыг түр хугацаанд хянах, ашиглах, захиран зарцуулах үйл ажиллагааг;

4.1.9. “төлбөр тооцооны хэрэгсэл гаргах” гэж бэлэн мөнгө, мөнгөн хөрөнгө шилжүүлэх, хүлээн авах, төлбөр төлөх зориулалттай төлбөрийн карт болон Хорооноос зөвшөөрсөн биет, биет бус хэрэгслийг;

4.1.10. “банк бус санхүүгийн байгууллагын холбогдох этгээд”/цаашид “холбогдох этгээд” гэх/ гэж хувьцааны хяналтын багцыг эзэмшдэг аливаа иргэн, хуулийн этгээд, тэдэнд хувьцааны хяналтын багцаа эзэмшүүлдэг хуулийн этгээд;

4.1.11. “банк бус санхүүгийн байгууллагын нэгдэл” гэж нэг хуулийн этгээд нь нөгөө хуулийн этгээдтэй холбогдох этгээд бөгөөд тэдгээрийн аль нэг нь банк бус санхүүгийн байгууллага байх тус тусдаа хуулийн этгээдийг;

4.1.12. “нэгдлийн оролцогч” гэж энэ хуулийн 4.1.11-д заасан нөхцөлийг хангах этгээдийг;

4.1.13. “нэгдсэн хяналт, шалгалт” гэж банк бус санхүүгийн байгууллагын нэгдлийн оролцогчийн санхүүгийн үйл ажиллагаанд дангаар болон нэгдсэн байдлаар хяналт шалгалт хийхийг;

4.1.14. “банк бус санхүүгийн байгууллага өөрчлөн байгуулах” гэж хууль тогтоомжид заасан журмын дагуу банк бус санхүүгийн байгууллагыг нийлүүлэх, нэгтгэх хуваах, тусгаарлах, өөрчлөхийг;

4.1.15. “банк бус санхүүгийн байгууллагын салбар, төлөөлөгчийн газар” гэж Иргэний хуулийн 29.2, 29.3-т заасныг;

4.1.16. “өөрийн хөрөнгийн хүрэлцээ” гэж банк бус санхүүгийн байгууллага нь санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлээс үүсэх алдагдлыг хаахад хүрэлцэхүйц хэмжээний өөрийн хөрөнгөтэй эсэхийг тодорхойлсон үнэлгээг;

4.1.17. “өөрийн хөрөнгийн шаардлага” гэж Хорооноос тогтоосон, энэ хуулийн 4.1.16-д заасан өөрийн хөрөнгийн хүрэлцээний доод хэмжээг;

4.1.18. “актив, пассив, өөрийн хөрөнгө” гэж олон улсын стандартад нийцүүлэн санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Хорооны даргын хамтран баталсан нягтлан бодох бүртгэлийн журамд тодорхойлсныг;

4.1.19. “төлбөр түргэн гүйцэтгэх чадвар” гэж бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг харилцагчийн анхны шаардлагаар буцаан олгох чадварыг;

4.1.20. “гадаад валютын ханшийн эрсдэл” гэж төгрөгийн гадаад валюттай харьцах ханш хэлбэлзэхэд алдагдал хүлээх эрсдэлийг;

4.1.21. “банк бус санхүүгийн дундын байгууллага” гэж банк бус санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгөөс оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдсэн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, банк бус санхүүгийн байгууллага нь эзэмшиж байгаа хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээдэг, ашгийн төлөө хуулийн этгээдийг.

## 5 дугаар зүйл. Банк бус санхүүгийн байгууллагын төрөл

5.1. Банк бус санхүүгийн байгууллага нь үүсгэн байгуулагдсан хэлбэрээр хязгаарлагдмал хариуцлагатай, хувьцаат компани хэлбэртэй байж болно.

### ХОЁРДУГААР БҮЛЭГ

Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа, тавигдах шаардлага, зохицуулалт, хориглох зүйл

## 6 дугаар зүйл. Банк бус санхүүгийн байгууллагын эрхлэх үйл ажиллагаа

6.1. Хорооны тусгай зөвшөөрөлтэйгөөр банк бус санхүүгийн байгууллага нь дараах үйл ажиллагаа эрхэлнэ:

6.1.1. зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд дараах төрлийн үйлчилгээг эрхэлнэ:

6.1.1.а. зээл;

6.1.1.б. баталгаа, батлан даалт гаргах;

6.1.1.в. факторинг;

6.1.1.г. санхүүгийн түрээс;

6.1.1.д. санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээ.

6.1.2. төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд дараах төрлийн үйлчилгээг эрхэлнэ:

6.1.2.а. цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ;

6.1.2.б. төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйлчилгээ.

6.1.3. хөрөнгө удирдлагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд дараах төрлийн үйлчилгээг эрхэлнэ:

6.1.3.а. итгэлцлийн үйлчилгээ;

6.1.3.б. санхүүгийн хэрэгсэл гаргах, худалдах, худалдан авах үйлчилгээ;

6.1.4. валют арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл

6.1.5. хуульд өөрөөр заагаагүй бол санхүүгийн компанийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр давхар эрхэлж болно.

6.1.5.а. даатгалын зуучлагч;

6.1.5.б. даатгалын хохирол үнэлгээ;

6.1.5.в. андеррайтер;

6.1.5.г. үнэт зүйл хадгалах;

6.1.5.д. хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлал.

6.2.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хуулиар хориглоогүй Хорооноос баталсан санхүүгийн бусад үйлчилгээг зөвшөөрлийн хүрээнд эрхэлж болно.

6.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 10.1.1, 10.1.4, 10.1.8-10.1.10-д заасан үйл ажиллагааг Хорооны дүгнэлтийг үндэслэн Монголбанкны зөвшөөрөлтэйгөөр эрхэлж төлбөрийн системд оролцож болно.

6.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг эрхэлж байгаа үйл ажиллагааны төрлөөс нь хамааруулан дараах байдлаар 4 ангилна.

6.4.1. энэ хуулийн 6.1.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийг “Зээлийн компани” гэх бөгөөд 6.1.2, 6.1.4-д заасан тусгай зөвшөөрлийг нэмж эрхэлж болно;

6.4.2. энэ хуулийн 6.1.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийг “Төлбөр тооцооны компани” гэх бөгөөд 6.1.4-д заасан тусгай зөвшөөрлийг нэмж эрхэлж болно;

6.4.3. энэ хуулийн 6.1.1 болон 6.1.3-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийг “Санхүүгийн компани” гэх бөгөөд 6.1.2, 6.1.4, 6.1.5-д заасан тусгай зөвшөөрлийг нэмж эрхэлж болно;

6.4.4. энэ хуулийн 6.1.4-д заасан үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийг “Валют арилжааны компани” гэж нэрлэнэ.

6.5.Энэ хуулийн 6.4-т заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ангиллаа өөрчлөх бол тухайн ангилалд Хорооноос тавьсан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан байна.

[7 дугаар зүйл. Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд тавигдах шаардлага, зохицуулалт](#)

7.1.Банк бус санхүүгийн байгууллагаас нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгох зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүн нь тухайн банк бус санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгийн 30 хувиас доошгүй байна.

7.2.Банк бус санхүүгийн байгууллагаас гаргах төлбөрийн баталгаа, батлан даалтын нийт дүн нь тухайн банк бус санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгийн нийт дүнгээс илүүгүй байна.

7.3.Тухайн банк бус санхүүгийн байгууллагын хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, бусад ажилтан болон энэ хуулийн 4.1.10-т заасан этгээдэд олгох зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, баталгааны дээд хэмжээ нь банк бус санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгийн 10 хувиас, тэдгээрийн нийлбэр дүн нь өөрийн хөрөнгийн 25 хувиас тус тус хэтэрч болохгүй бөгөөд олгосон зээлийн төлөгдөх хугацаа нь зургаагаас дээш сараар хэтэрсэн бол тухайн этгээд банк бус санхүүгийн байгууллагын удирдах үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр оролцохыг хориглоно.

7.4. Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь Хорооноос тогтоосон хэм хэмжээ, зохистой харьцаа, баталсан журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

7.5.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ангилал, үйл ажиллагааны төрөлд тавигдах нэмэлт шаардлагыг зохицуулсан журмыг Хороо батална.

7.6.Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох болон бүртгэх үйл ажиллагаатай холбоотой нарийвчилсан харилцааг зохицуулсан журмыг Хороо батална.

7.7.Банк бус санхүүгийн болон тэдгээрийн санхүүгийн дундын байгууллагын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, гадаад валютын болон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Хороо тогтоож, батална.

7.8.Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмыг төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хорооны даргын хамтарсан тушаалаар батална.

7.9.Банк бус санхүүгийн үйл ажиллагаа, үйлчилгээний төрөл, санхүүгийн дэвшилтэд технологи нэвтрүүлэх, хэрэглэгчдийг хамгаалах, мэдээллийн ил тод байдлыг хангахтай холбоотой хяналт, зохицуулалтын журам, зааврыг Хорооноос баталж болно.

7.10.Чөлөөт бүсэд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдэд тавигдах шаардлага болон бусад зохицуулалтыг Хорооноос баталсан журмаар зохицуулна.

7.11.Банк бус санхүүгийн байгууллага нь нээлттэй компанийн хэлбэрт шилжих асуудлыг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хорооноос тогтоосон журмаар зохицуулна.

## 8 дугаар зүйл.Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхэд хориглох зүйл

8.1.Банк бус санхүүгийн байгууллага нь дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

8.1.1.энэ хуулийн 6 дугаар зүйлд зааснаас бусад төрлийн үйл ажиллагаа, үйлчилгээ эрхлэх;

8.1.2.өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа мэдээлэл нийтэд тараах;

8.1.3.банк бус санхүүгийн байгууллагын тайлан тэнцэлд тусгаагүй эх үүсвэрийг өөрийн үйл ажиллагаанд ашиглах;

8.1.4.банк бус санхүүгийн байгууллагын хувьцаа эзэмшигчийн хувь нийлүүлсэн хөрөнгөнд оруулсан хөрөнгийг барьцаалан зээл олгох, батлан даалт гаргах.

8.2.Зээлийн барьцаалсан эд хөрөнгийг зээл төлүүлэх зорилгоор эзэмших, худалдаж борлуулах үйл ажиллагаа энэ хуулийн 8.1.4-д хамаарахгүй.

8.3.Өөрийн компани, харилцагч болон гуравдагч этгээд нууц гэж үзсэн аливаа мэдээллийг дор дурдсанаас бусад тохиолдолд бусдад гаргаж өгөх, задруулах, ашиглахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, дотоод хяналтын албаны дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, ажилтанд хориглоно:

8.3.1.Хороо, түүний хянан шалгагч хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан;

8.3.2.Шүүх, прокурорын байгууллагын удирдлага хүсэлт гаргасан, эсхүл авилгатай тэмцэх байгууллага, тагнуул, цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны шаардлагаар тэдгээрийн удирдлагын хүсэлтийг прокурор зөвшөөрсөн.

8.4.Банк бус санхүүгийн байгууллагаас олгосон зээлийн талаарх эрх бүхий байгууллага хоорондын мэдээлэл, зээлийн мэдээллийн санд гаргаж өгөх мэдээлэл, энэ хуулийн 23, 24 дугаар зүйлд заасан тайлан, мэдээлэл энэ хуулийн 8.3-д хамаарахгүй.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

Банк бус санхүүгийн байгууллагыг үүсгэн байгуулах, тусгай зөвшөөрөл олгох, бүртгэх, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, өөрчлөн байгуулах, татан буулгах

## 9 дүгээр зүйл.Банк бус санхүүгийн байгууллагыг үүсгэн байгуулах

9.1.Банк бус санхүүгийн байгууллагыг Компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулна.

9.2.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, шашны, улс төрийн, төрийн бус байгууллага, сан, тэдгээртэй холбогдох этгээдээс бусад хуулийн этгээд, иргэн банк бус санхүүгийн байгууллага үүсгэн байгуулж болно.

9.3.Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, өөрчлөн байгуулах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон өргөдөл хүсэлтийг Хороо шийдвэрлэнэ.

#### 10 дугаар зүйл.Банк бус санхүүгийн байгууллага үүсгэн байгуулахад тавигдах шаардлага

10.1.Хувь нийлүүлсэн хөрөнгө нь Хорооноос тогтоосон доод хэмжээг хангасан байна.

10.2.Хувь нийлүүлсэн хөрөнгөнд оруулах мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны үйл ажиллагааны орлого байна.

10.3.Удирдлага нь энэ хуулийн 21-д заасан шалгуурыг хангасан байна.

10.4.Энэ хуулийн 11 дүгээр зүйл, 12 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

#### 11 дүгээр зүйл.Банк бус санхүүгийн байгууллага үүсгэн байгуулахад бүрдүүлэх баримт бичиг

11.1.Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1-д заасан болон дараах баримт бичгийг бүрдүүлж Хороонд ирүүлнэ:

11.1.1. Хорооноос баталсан маягтын дагуу үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл;

11.1.2. хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, шийдвэр;

11.1.3. дүрэм, холбогдох үйл ажиллагааны журам;

11.1.4. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

11.1.5. Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан болохыг нотлох банкны тодорхойлолт, холбогдох дансны хуулга;

11.1.6. хувьцаа эзэмшигчийн хувь нийлүүлэх хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны үйл ажиллагааны орлогоос бүрдсэн болохыг нотлох баримт бичиг;

11.1.7. үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө;

11.1.8. санхүүгийн эхлэлтийн тайлан;

11.1.9. хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, боловсон хүчин, техник, тоног төхөөрөмж, ажлын байрны талаарх мэдээлэл.

11.2.Энэ хуулийн 11.1-д заасан баримт бичгийн бүрдэл дутуу, шаардлага хангаагүй гэж үзвэл Хороо нэмэлт баримт бичиг шаардах эрхтэй бөгөөд шаардлагатай асуудлаар холбогдох байгууллагаас тодорхойлолт, лавлагаа гаргуулан авч болно.

#### 12 дугаар зүйл.Банк бус санхүүгийн байгууллагын дүрэм

12.1.Банк бус санхүүгийн байгууллагын дүрэмд Компанийн тухай хуулийн 16.2-т заасан болон дараах зүйлийг тусгана:

12.1.1. хувьцаа эзэмшигчдийн бүртгэл, тэдгээрийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, эзэмшиж байгаа хувьцааны тоо;

12.1.2. удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтэц;

12.1.3. эрхлэх үйл ажиллагааны төрөл.

12.2. Банк бус санхүүгийн байгууллага нь дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлтийг Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлж, бүртгүүлснээс хойш ажлын 15 өдрийн дотор Хороонд хүргүүлнэ.

### 13 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох

13.1. Тусгай зөвшөөрөл хүсэж ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг Хороо хүлээн авч энэ хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу хянаж, ажлын 45 өдрийн дотор Хорооны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

13.2. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдөл, баримт бичгийн бүрдлийг Хороо хянасны эцэст хүлээн авах, шаардлагатай нэмэлт баримт бичгийг бүрдүүлж өгсөн өдрөөс өргөдлийн хугацааг тооцно.

13.3. Ирүүлсэн баримт бичгийг магадлан шинжлэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд Хороо энэ хуулийн 13.1-д заасан хугацааг ажлын 10 өдрөөр сунгаж болно.

13.4. Тусгай зөвшөөрлийг хугацаагүй олгох ба уг зөвшөөрөл нь олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

13.5. Хорооноос тусгай зөвшөөрөл авсан банк бус санхүүгийн байгууллага Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлж, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ажлын 15 өдөрт Хороонд ирүүлнэ.

### 14 дүгээр зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах

14.1. Энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй.

14.2. Ирүүлсэн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн нь баримтаар тогтоогдсон.

14.3. Хувь нийлүүлсэн хөрөнгийг зээлийн эх үүсвэрээр бүрдүүлсэн нь баримтаар тогтоогдсон.

14.4. Ирүүлбэл зохих баримт бичгийг анх хүсэлт тавьсан өдрөөс хойш 3 сарын хугацаанд бүрэн бүрдүүлээгүй.

14.5. Энэ хуулийн 14.2, 14.3, 14.4-д заасан үндэслэлүүдээр Хороо тусгай зөвшөөрлийг олгохоос татгалзсанаас хойш 1 жилийн дотор тухайн хуулийн этгээдээс дахин зөвшөөрөл хүссэн хүсэлтийг хүлээн авахгүй.

### 15 дугаар зүйл. Банк бус санхүүгийн байгууллагын зөвшөөрлийн бүртгэл

15.1. Банк бус санхүүгийн байгууллагын оноосон нэр, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, салбар, төлөөлөгчийн газар шинээр нээхдээ Хорооны даргын шийдвэрээр зөвшөөрөл авч, тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглэл хийлгэнэ.

15.2. Энэ хуулийн 6.4-т заасан хуулийн этгээд нь 6.1-д заасан тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхэлж буй үйл ажиллагааны төрлийг Хороонд бүртгүүлж тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд тэмдэглээ хийлгэн зохих журмын дагуу холбогдох мэдээллээ ирүүлж байна.

15.3. Хувьцаат компани хэлбэрээр зохион байгуулагдсан банк бус санхүүгийн байгууллагын хувьцааг олон нийтэд нээлттэй арилжаалахаар Хорооноос зөвшөөрөл авсан тохиолдол 22.4 дахь заалт хамаарахгүй бөгөөд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар зохицуулалтын хүрээнд бүртгэл хийнэ.

15.4. Үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллага нь хувьцаат компанийн хэлбэрээр байгуулагдсан банк бус санхүүгийн байгууллагын хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээг Хорооноос тогтоосон журмын дагуу ирүүлнэ.

15.5. Банк бус санхүүгийн байгууллагын төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх болон салбарын удирдлага, хаяг байршил, өөрчлөлтийг Хороонд бүртгүүлнэ.

#### 16 дугаар зүйл. Банк бус санхүүгийн байгууллагын нэр

16.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр нь түүний оноосон нэр болон энэ хуулийн 6.4.1, 6.4.2, 6.4.3, 6.4.4-т заасан ангиллын дэлгэрэнгүй тэмдэглэгээ, эсхүл “ЗК”, “ТТК”, “СК”, “ВАК”, гэсэн товчилсон тэмдэглэгээнээс бүрдэнэ.

16.2. Энэ хуулийн 6.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээс өөр хуулийн этгээд өөрийн оноосон нэртэй хамт энэ хуулийн 16.1-д заасан тэмдэглэгээ хэрэглэхийг хориглоно.

16.3. Банк бус санхүүгийн байгууллагын салбар, төлөөлөгчийн газар нь үндсэн банк бус санхүүгийн оноосон нэрийг хэрэглэнэ.

#### 17 дугаар зүйл. Банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох

17.1. Хороо банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр түдгэлзүүлж болно:

17.1.1. энэ хуулийн 22.2-т заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангаагүй;

17.1.2. энэ хуулийн 22.4-д заасныг зөрчсөн;

17.1.3. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд Хорооноос хийсэн зайны болон газар дээрх шалгалтын дүгнэлтийг үндэслэн;

17.1.4. тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Хорооноос хийх хяналт шалгалтаас санаатайгаар зайлсхийсэн;

17.1.5. тусгай зөвшөөрөлд тавигдсан шаардлага хангаагүй;

17.1.6. хувь нийлүүлсэн хөрөнгийг тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанаас бусад зориулалтын бус зүйлд зарцуулсан;

17.1.7. хуульд тогтоомжид заасан бусад үндэслэлээр.

17.2. Энэ хуулийн 18.1-д заасан түдгэлзүүлсэн үндэслэлийг Хорооноос тогтоосон хугацаанд арилгасан бол тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс ирүүлсэн хүсэлтийг үндэслэн Хорооны хуралдаанаар хэлэлцэн сэргээнэ.

17.3. Хороо тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгож болно:

17.3.1. тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрөө хүсэлт гаргасан;

17.3.2. түдгэлзүүлсэн хугацаанд гаргасан зөрчлийг арилгах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй;

17.3.3. тухайн төрлийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд тухайн үйлчилгээг эрхэлсэн;

17.3.4. тухайн банк бус санхүүгийн байгууллага нь дампуурсан буюу төлбөрийн чадваргүй болсныг зарласан, эсхүл татан буугдсан тухай эрх бүхий байгууллага, хувьцаа эзэмшигчдийн хурлаас зарласан;

17.3.5. банк бус санхүүгийн байгууллага нь 1 жилээс дээш хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй;

17.3.6. хуульд заасан бусад.

17.4. Хороо банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай мэдээллийг олон нийтэд мэдээлнэ.

17.5. Хороо тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш 1 жилийн дотор тухайн хуулийн этгээдээс дахин зөвшөөрөл хүссэн хүсэлтийг хүлээн авахгүй.

17.6. Хуульд заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосноос хувьцаа эзэмшигчид учирсан хохирлыг Хороо хариуцахгүй.

**18 дугаар зүйл. Банк бус санхүүгийн байгууллагыг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр өөрчлөн байгуулж, татан буулгах**

18.1. Банк бус санхүүгийн байгууллагыг Хорооны зөвшөөрлийг үндэслэн Компанийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн дагуу өөрчлөн байгуулж, татан буулгаж болно.

18.2. Банк бус санхүүгийн байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай зөвшөөрөл авахад дор дурдсан баримт бичгийг Хороонд гаргаж өгнө:

18.2.1. өөрчлөн байгуулах, татан буулгах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр;

18.2.2. өөрчлөн байгуулах, татан буулгах шаардлага, хэлбэр, нөхцөл, хугацааг заасан баримт бичиг, санхүүгийн үйл ажиллагааг дуусгавар болгохтой холбогдуулан авах арга хэмжээ, тэдгээрийн хугацаа, үе шат, хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, аудитын байгууллага /аудитор/-аар баталгаажуулсан санхүүгийн тайлан болон шаардлагатай бусад мэдээлэл;

18.2.3. өөрчлөн байгуулснаас гарах санхүүгийн үр дүнгийн тооцоо, өөрчлөн байгуулсны дараах санхүүгийн эхлэлтийн тайлан.

18.3. Хороо баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 30 өдрийн дотор тусгай зөвшөөрөл эзэмшигчийг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай холбогдох асуудлыг шийдвэрлэж нийтэд мэдээлнэ.

18.4. Өөрчлөн байгуулах, татан буулгах зөвшөөрөл олгосны дараа банк бус санхүүгийн байгууллагыг өөрчлөн байгуулах, татан буулгах ажиллагаа эхэлнэ.

18.5. Банк бус санхүүгийн байгууллага нь Хорооноос өөрчлөн байгуулах, татан буулгах талаар гарсан шийдвэрийг гаргаснаас хойш ажлын 10 өдрийн дотор харилцагчдадаа мэдэгдэнэ.

18.6. Өөрчлөн байгуулах, татан буулгах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хууль тогтоомж зөрчсөн, харилцагчийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөр бол Хороо зөвшөөрөл өгөхөөс татгалзана.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

**19 дүгээр зүйл. Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчдэд тавигдах шаардлага**

19.1. Банк бус санхүүгийн байгууллагын үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчид нь энэ хуулийн 21.2.2-т заасан шаардлагыг хангасан байна.

19.2. Банк бус санхүүгийн байгууллагын нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч нь дараах шалгуурыг хангасан байна:

19.2.1. тухайн этгээд нь дампуурлын хэргийн хариуцагч, эсхүл хариуцагч хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан бус байх;

19.2.2. банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхүйц нөхцөл байдал үүсгэхгүй байх;

19.2.3. тухайн хувьцааны эцсийн өмчлөгчийг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасны дагуу нотолсон байна.

19.3. Банк бус санхүүгийн байгууллагын нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол дараах шаардлагыг хангасан байна:

19.3.1. тухайн улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу санхүүгийн тайлан, мэдээгээ тухай бүр тайлагнадаг байх;

19.3.2. санхүүгийн тайлангаа жил бүр аудитын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагаар баталгаажуулж, Хороонд ирүүлдэг байх;

19.3.3. банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгөнд оруулах мөнгөн хөрөнгө нь тухайн этгээд, түүнтэй холбогдох этгээдийн санхүүгийн тайлангаар тодорхойлогдсон, хууль ёсны үйл ажиллагааны орлого байх.

## 20 дугаар зүйл. Хувьцаа эзэмшигчдийн хурал

20.1. Банк бус санхүүгийн байгууллагын эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд нэг хувьцаа эзэмшигчтэй бол хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хувьцаа эзэмшигч өөрөө хэрэгжүүлнэ.

20.2. Банк бус санхүүгийн байгууллагын хувьцаа эзэмшигчдийн хурал дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:

20.2.1. хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүн, хэмжээг өөрчлөх;

20.2.2. компанийн тухай хуульд заасан бусад.

20.3. Банк бус санхүүгийн дундын байгууллагын эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд нь энэ хуулийн 20.2 дахь заалт нэгэн адил хамаарна.

## 21 дүгээр зүйл. Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага

21.1. Энэ хуулийн 6.4.2-т заасан үйл ажиллагаа эрхлэх санхүүгийн байгууллага, өрийн бичиг гаргасан зээлийн компани болон банк бус санхүүгийн дундын байгууллага нь нэг буюу түүнээс дээш тооны хараат бус, нийт 5-аас доошгүй гишүүн бүхий төлөөлөн удирдах зөвлөлтэй байна.

21.2. Банк бус санхүүгийн байгууллагын төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх болон салбарын удирдлага нь дараах шаардлагыг хангасан байна:

21.2.1. зээлийн гэрээ буюу өрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд төлбөрийн баталгаа, батлан даалтаар хүлээсэн чанаргүй зээлийн өргүй;

21.2.2. мөнгө угаах болон эдийн засгийн гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй;

21.2.3. дээд боловсролтой, банк, санхүү, эдийн засгийн чиглэлээр мэргэшсэн, тухайн салбарт ажилласан, үүнээс хоёроос доошгүй жил банк, санхүүгийн байгууллагад эрх бүхий албан тушаал хашсан туршлагатай байх;

21.2.4. компанийн тухай хуулийн 75.8-д заасан шаардлагыг хангасан байна.

## ТАВДУГААР БҮЛЭГ

### ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 22 дугаар зүйл. Өөрийн хөрөнгө

22.1. Банк бус санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгийг санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Хорооны даргын хамтран баталсан нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу тодорхойлно.

22.2. Хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаа эзэмшигчдээс оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний хэмжээг тогтоохдоо улсын эдийн засгийн байдал, төгрөгийн ханшийн өөрчлөлт, салбарын хөгжлийн чиг хандлага, эрхлэх үйл ажиллагааны ангилал, үйл ажиллагааны төрөл, газар зүйн байршлыг харгалзан Хороо тогтооно.

22.3. Хувьцаа эзэмшигч хувь нийлүүлсэн хөрөнгөнд оруулсан хөрөнгийн хэмжээгээр санхүүгийн хариуцлага хүлээж, алдагдлыг нөхнө.

22.4. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, худалдан авах, шилжүүлэх тухай бүрд Хорооны даргын шийдвэрээр зөвшөөрөл авсан байна.

### 23 дугаар зүйл. Санхүүгийн тайлан

23.1. Санхүүгийн тайлан нь санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдэнэ.

23.2. Тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн санхүүгийн тайлангийн үзүүлэлт, дансны жагсаалт, маягт нь санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Хорооны даргын хамтран баталсан нягтлан бодох бүртгэлийн багц журам, заавартай нийцсэн байна.

23.3. Банк бус санхүүгийн байгууллага нь санхүүгийн үйл ажиллагааны мэдээллийн санг давагдашгүй хүчин зүйл, бусад аюулаас сэргийлэх зорилгоор архивын биет болон цахим хэлбэрээр хадгална.

23.4. Хороо нь санхүүгийн тайлан, мэдээллийн үнэн зөв эсэхэд хяналт тавьж, зохих журмыг баримтлаагүй, буруу, ташаа, алдаатай бол залруулахыг шаардаж, биелэлтэд хяналт тавьж ажиллана.

### 24 дүгээр зүйл. Санхүүгийн тайлан, бусад шаардлагатай мэдээллийг тайлагнах

24.1. Банк бус санхүүгийн байгууллага нь холбогдох мэдээ болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн сарын тайланг дараа сарын 10-ны дотор, улирлын санхүүгийн тайлан, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайланг дараа улирлын эхний сарын 10-ны дотор Хороонд хүргүүлнэ.

24.2. Хороо санхүүгийн тайлантай холбогдсон нэмэлт тодруулгыг банк бус санхүүгийн байгууллага, түүний нэгдлийн оролцогч толгой компани, тэдгээрийн хараат болон охин компаниас шаардах эрхтэй.

24.3. Банк бус санхүүгийн байгууллага, нэгдлийн оролцогч, түүнтэй холбогдох этгээд болон эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь Хорооны хянан шалгагчийг бүрэн эрхээ хэрэгжүүлэх нөхцөл, бололцоогоор хангана.

### 25 дугаар зүйл. Санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулах

25.1. Банк бус санхүүгийн байгууллага нь жилийн эцсийн санхүүгийн тайланг тусгай зөвшөөрөл бүхий аудитын байгууллагаар Аудитын тухай хуулийн 10.2.4-т заасан хугацаанд санхүүгийн тайлангаа баталгаажуулж, Хороонд хүргүүлнэ.

25.2. Аудитын байгууллага нь санхүүгийн тайланг баталгаажуулсан дүгнэлтийг тухайн банк бус санхүүгийн байгууллагын төлөөлөн удирдах зөвлөл, хянан шалгах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад танилцуулна.

## ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо

## 26 дугаар зүйл. Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо

26.1.Банк бус санхүүгийн байгууллагууд, мэргэжлийн холбоод нь хууль ёсны эрх ашгаа хамгаалуулах, хамтран ажиллах зорилгоор нэгдэн холбоо/цаашид “Холбоо” гэх/ байгуулж болно.

26.2.Холбоо нь холбооны эрх, үүргийг хэрэгжүүлж гишүүн байгууллагуудын эрх ашгийг хамгаалах, тэдгээрийг төрийн байгууллага болон гадаад харилцаанд төлөөлөх эрхийг эдэлнэ.

26.3.Холбоо нь дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэхтэй холбоотойгоор гишүүн байгууллагуудынхаа санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн туслалцаа үзүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор дэргэдээ сан үүсгэн байгуулж болно.

## 27 дугаар зүйл. Холбооны бүтэц, удирдлага, зохион байгуулалт, хяналтын тогтолцоо

27.1.Холбоо нь Бүх гишүүдийн хурал, Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл, Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал, ажлын алба гэсэн үндсэн бүтэцтэй байна.

27.1.1.холбооны эрх барих дээд байгууллага нь Холбооны Бүх гишүүдийн хурал байна.

27.1.2.бүх гишүүдийн хурлыг холбооны Удирдах Зөвлөл жилд нэгээс доошгүй удаа зарлан хуралдуулна.

27.1.3.удирдах зөвлөлийн гишүүнийг 2 жилийн, хяналтын зөвлөлийн гишүүнийг 3 жилийн хугацаатайгаар бүх гишүүдийн хурлаас хаалттай санал хураалтаар сонгож, чөлөөлөх бөгөөд Холбооны дүрмээр нарийвчилсан харилцааг зохицуулна.

27.1.4.удирдах зөвлөл нь Холбооны Ерөнхийлөгчийг хаалттай санал хураалтаар 3 жилийн хугацаатай сонгох бөгөөд 1 удаа улируулан сонгож болно.

## 28 дугаар зүйл. Холбооны чиг, үүрэг

28.1.Холбоо нь дараах эрх эдэлнэ:

28.1.1.гишүүдийнхээ хууль ёсны эрх, нийтлэг ашиг сонирхлыг төлөөлөх, хамгаалах;

28.1.2.холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр төрийн байгууллагад санал өгөх;

28.1.3.гишүүдийнхээ үйл ажиллагаанд баримтлах нийтлэг журам, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг батлах, хэрэгжилтийг хангуулах;

28.1.4.хуульд заасан нууцад хамаарахаас бусад мэдээллийг гишүүн байгууллагаас гаргуулах;

28.1.5.хуулийн хүрээнд гишүүдийн үйл ажиллагааг дэмжих, олон нийтэд сурталчлах;

28.1.6.хуульд заасан бусад.

28.2.Холбоо нь дараах үүрэг хүлээнэ:

28.2.1.гэрээний үндсэн дээр төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх;

28.2.2.салбарын нэгдсэн сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;

28.2.3.гишүүдийн мэргэжлийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг бууруулах нөхцөлийг судлах;

28.2.4.гишүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах;

28.2.5.салбарын үйл ажиллагаанд судалгаа, шинжилгээ хийж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, дүгнэлт гаргах;

28.2.6. гишүүдийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Хороо болон эрх бүхий бусад байгууллагаас ирүүлсэн аливаа мэдээллийг гишүүн бүрд шуурхай хүргэх;

28.2.7. Хорооноос олгосон зөвшөөрлийн хүрээнд гишүүн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих;

28.2.8. хуульд заасан бусад.

### 29 дүгээр зүйл. Холбооны хөрөнгийн эх үүсвэр

29.1. Холбооны хөрөнгө нь дараах эх үүсвэрээс бүрдэж болно:

29.1.1. гишүүний татвар, хандив, төлбөр;

29.1.2. гадаад, дотоодын этгээдээс оруулсан хандив, зээл, тусламж;

29.1.3. дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааны орлого;

29.1.4. хууль тогтоомжоор хориглоогүй, дүрэмд заасан бусад эх үүсвэр.

## ДОЛДУГААР БҮЛЭГ

### БАНК БУС САНХҮҮГИЙН ДУНДЫН БАЙГУУЛЛАГА

#### 30 дугаар зүйл. Банк бус санхүүгийн дундын байгууллага

30.1. Тусгай зөвшөөрөл бүхий банк бус санхүүгийн байгууллагууд нийлж, үйл ажиллагаагаа өргөтгөх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг дамжуулан зээлдүүлэх үйлчилгээ үзүүлэх зорилгоор ашгийн төлөө банк бус санхүүгийн дундын байгууллага / цаашид дундын байгууллага/-ыг үүсгэн байгуулж болно.

30.2. Дундын байгууллага нь дараах үйл ажиллагаа эрхэлнэ:

30.2.1. энэ хуулийн 6.1, 6.2-д заасан үйл ажиллагаа, үйлчилгээ;

30.2.2. мөнгөн хадгаламжийн үйлчилгээ;

30.3. Дундын байгууллагын 30.2.1, 30.2.2-т заасан тусгай зөвшөөрлийг Хороо олгоно.

30.4. Дундын байгууллага нь энэ хуулийн 6.3-т заасан үйл ажиллагааг эрхэлж болно.

30.5. Дундын байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг Хороо тогтоож, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэх үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтын журмыг батална.

30.6. Дундын байгууллага нь тусгай зөвшөөрөл авахдаа энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан баримт бичгийг бүрдүүлэх бөгөөд хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

30.7. Энэ хуулийн 7.1-7.3 дахь заалт болон 12-15, 18-21, 23-25 дугаар зүйл дундын байгууллагад нэгэн адил хамаарна.

#### 31 дүгээр зүйл: Дундын байгууллагын үйл ажиллагаа эрхлэхэд хориглох зүйл

31.1. Дундын байгууллага нь дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

31.1.1. энэ хуулийн 30.2-д зааснаас бусад төрлийн үйл ажиллагаа эрхлэх;

31.1.2. энэ хуулийн 8.1.2-8.1.4 дэх заалт нэгэн адил хамаарна.

## НАЙМДУГААР БҮЛЭГ

### БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ, ХҮЛЭЭЛГЭХ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ

#### 32 дугаар зүйл. Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналт, шалгалт

32.1. Хороо энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу банк бус санхүүгийн байгууллагын болон дундын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, шалгалт хийнэ.

32.2. Банк бус санхүүгийн байгууллагын болон дундын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон эрсдэлд суурилсан хяналт шалгалт, газар дээрх хяналт болон үнэлгээ хийх журмыг Хороо батална.

32.3. Хороо нь хяналт, шалгалт болон шаардлагатай бусад тохиолдолд тухайн банк бус санхүүгийн болон дундын байгууллагын үйл ажиллагаатай холбоотойгоор бусад этгээдээс тодруулга, мэдээлэл авах эрхтэй.

#### 33 дугаар зүйл. Нэгдсэн хяналт, шалгалт хийх

33.1. Хороо нь банк бус санхүүгийн байгууллагын нэгдлийн оролцогчийн үйл ажиллагаанд нэгдсэн хяналт шалгалт хийх шаардлагатай гэж үзвэл дангаараа эсхүл санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Монголбанкт хамтран хийх бөгөөд түүнд хамрагдах хуулийн этгээдийн санхүүгийн тайланг нэгдсэн байдлаар гаргаж үнэлэлт, дүгнэлт өгнө.

33.2. Нэгдлийн оролцогч нь өөр улсад бүртгэгдсэн буюу байршдаг бол Хороо тухайн орны эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцох, хамтран ажиллаж нэгдсэн хяналт, шалгалтыг хэрэгжүүлж болно.

33.3. Энэ хуулийн 33.1-д заасан нэгдсэн хяналт шалгалтыг нэгдлийн оролцогчдын санхүү, төлбөрийн чадвар, тэдгээрийн хоорондох хөрөнгийн урсгал, нэг оролцогчоос нөгөөд оруулсан хөрөнгө, өглөг, авлага, зээл, нэгдлийн оролцогчдын хоорондын санхүүгийн бусад үүрэг, ажил, гүйлгээний хамаарлыг тэдгээрийн болон тэдгээртэй холбогдох этгээдийн санхүүгийн үйл ажиллагааны мэдээ, мэдээлэлд үндэслэн тодорхойлж, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тэдгээрийн нэгдлийн оролцогчийн санхүү, төлбөрийн чадвар нь шаардлагыг хангаж байгаа эсэхийг дангаар нь болон нэгдсэн байдлаар тодорхойлон үнэлэлт, дүгнэлт өгөх байдлаар хийнэ.

33.4. Нэгдлийн оролцогч нь Хорооноос шаардсан мэдээллийг тогтоосон хугацаанд тухайн нэгдлийн оролцогч санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл эзэмшигчээр дамжуулан гаргаж өгнө.

#### 34 дүгээр зүйл. Нэгдсэн хяналт шалгалтад хамрагдахгүй байх нөхцөл

34.1. Хороо нэгдсэн хяналт шалгалтын үйл ажиллагаанд банк бус санхүүгийн байгууллагын нэгдлийн оролцогчийг дараах тохиолдолд оролцуулахгүй байж болно:

34.4.1. үйл ажиллагааны төрөл, хэмжээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн санхүү, төлбөрийн чадварын байдалд нөлөө үзүүлдэггүй;

34.4.2. тухайн хуулийн этгээдийг нэгдсэн хяналт шалгалтад хамруулахгүй байх нь нэгдсэн хяналт шалгалтын үйл ажиллагаа зохих ёсоор хэрэгжүүлэхэд саад болохооргүй;

34.4.3. нэгдсэн хяналт шалгалтад хамруулахгүй бол энэ тухай Хороо тухайн банк бус санхүүгийн байгууллага болон түүний толгой компани, тухайн оролцогчид мэдэгдэнэ.

### 35 дугаар зүйл. Банк бус санхүүгийн байгууллагад хүлээлгэх албадлагын арга хэмжээ

35.1. Банк бус санхүүгийн байгууллага нь энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлага, Хорооны бүрэн эрхэд хамаарах асуудлаар гаргасан шийдвэрийг зөрчсөн нь хяналт, шалгалтаар тогтоогдсон нөхцөлд Хороо дор дурдсан албадлагын арга хэмжээ авна:

35.1.1. албан бичгээр сануулах, зөрчлийг арилгах талаар хугацаатай үүрэг, даалгавар өгөх;

35.1.2. зөрчлийн тухай хуульд заасан захиргааны шийтгэл ногдуулах;

35.1.3. үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоох, түдгэлзүүлэх;

35.1.4. тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох;

35.1.5. үйл ажиллагааг зохистой явуулах талаар зөвлөх үүрэг бүхий дадлага туршлагатай мэргэжилтэн томилох.

35.2. Албадлагын арга хэмжээ авах тухай Хорооны шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл тухайн этгээд шүүх, хяналтын байгууллагад гомдол гаргаж болно.

35.3. Албадлагын арга хэмжээ ногдуулсан нь бусад хууль тогтоомжийн дагуу хүлээлгэх хариуцлагаас тусгай зөвшөөрөл эзэмшигч, түүний эрх бүхий албан тушаалтныг чөлөөлөх үндэслэл болохгүй.

### 36 дугаар зүйл. Хороо дундын байгууллагын эд хөрөнгийг хамгаалах зорилгоор шүүхэд нэхэмжлэл гаргах

36.1. Дундын байгууллагын хувь нийлүүлэгч, харилцагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор зорилгоор Хороо шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

36.2. Хороо энэ хуулийн 36.1-д заасан нэхэмжлэл гаргахдаа дундын байгууллагад мэдэгдэх үүрэг хүлээхгүй.

36.3. Энэ хуулийн 36.1-д заасан нэхэмжлэлийн дагуу шүүх дараах арга хэмжээг хэрэгжүүлж болно:

36.3.1. дундын байгууллагын эзэмшилд буй өмч хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах зэрэг хэлцэл хийхийг хориглосон шийдвэр гаргах;

36.3.2. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх болон хүчингүй болгохоос өмнө дундын байгууллагын үйл ажиллагааг удирдан зохицуулах бүрэн эрхт төлөөлөгчийг томилох;

36.3.3. дундын байгууллагыг татан буулгах;

36.3.4. дундын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар мэдээлэл авахаар холбогдох этгээдийг дуудан ирүүлэх.

36.4. Шүүх энэ хуулийн 36.3.2-т заасан бүрэн эрхт төлөөлөгчийг томилохдоо түүний эрх хэмжээ, цалин хөлс, шүүх болон Хороонд тайлан мэдээ гаргаж өгөх журмыг тогтооно.

36.5. Шүүх бүрэн эрхт төлөөлөгчийн талаар дараах арга хэмжээг авч болно:

36.5.1. эрх үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбогдуулан даалгавар, зааварчилга өгөх;

36.5.2. эрх хэмжээг нь өөрчлөх;

36.5.3. бүрэн эрхийг нь дуусгавар болгох.

## ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

### Хариуцлага

37 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

37.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

37.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

38 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

38.1. Энэ хуулийг 2018 оны ... дүгээр сарын...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА .....** /...../